

# ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар А-93

Улаанбаатар  
хот

Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх,  
хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 10.1.5 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг 14 дүгээр зүйлийн 14.1.4, 15 дугаар зүйлийн 15.11.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны 2/398 тоот албан бичгээр ирүүлсэн шалгалтын дүнгийн дагуу “Моннорсе” ХХК, “Магос” ХХК, “ЦЛМ” ХХК, “Баяндэлхий уулын цоохор” ХХК, “Шинэ Уул ветс” ХХК, “Уянга найман нуур” ХХК, “Мон оол вет” ХХК-ийн мал эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрлийг 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. “Хан бүргэдэй” ХХК, “Цамбагарав шүтээн” ХХК, “Амарвет” ХХК, “Тахилт номгон” ХХК, “Ач үр” ХХК, “Ажигана мах импекс” ХХК, “Бинсэ” ХК, “Үржинбадрах” ХХК, “Энх нэүрит” ХХК, “Евро фарм” ХХК, “Монголын хүний хөгжлийн бодлого судлалын хүрээлэн” ТББ, “Стар трейд” ХХК, “Пи Пи Пи Эм Жи Эль” ХХК, “Чандмань зэндмэнэ хайрхан” ХХК, “Эрдэнэбаян дэлгэрэх” ХХК-ийн мал эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, “Шинэ эхлэл түм” ХХК, “Зуун наст ЭМҮ” ХХК-ийн малын эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг тус тус 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөр тасалбар болгон хүчингүй болгосонд тооцсугай.

3. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэрийг аж ахуйн нэгж болон холбогдох байгууллагуудад албан бичгээр мэдэгдэхийг Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /М.Энх-Амар/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг эс зөвшөөрвөл хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 өдрийн дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д.ЭНХБАТ